

ГАДААДАД ЗОРЧИГЧИЙН ИЖ БҮРЭН ДААТГАЛЫН ГЭРЭЭ

Энэхүү гэрээг нэг талаас: МОНХ ДААТГАЛ ХХК (цаашид "Даатгагч" гэх) нөгөө талаас: Өөрийн ашиг сонирхлын төлөө даатгалын зүйлээ даатгуулж, Даатгагчтай гэрээ байгуулсан иргэн (цаашид "Даатгуулагч" гэх) нар (цаашид хамтад нь "Талууд" гэх) харилцан тохиролцож Монгол Улсын Иргэний хууль, Даатгалын тухай хуульд тус тус үндэслэн дор дурдсан нөхцөлөөр энэхүү "ГАДААДАД ЗОРЧИГЧИЙН ИЖ БҮРЭН ДААТГАЛЫН ГЭРЭЭ" (цаашид "гэрээ" гэх)-г байгуулав.

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү гэрээний зорилго нь гадаад улс оронд зорчих хугацаанд гэнэтийн осол аваар болон гэнэтийн өвчлөлийн улмаас Даатгуулагчийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохирлыг Даатгагч мөнгөн хэлбэрээр нөхөн төлөхөд оршино.
- 1.2 Даатгалын хамгаалалт нь даатгалын хураамж төлөгдсөн өдрөөс баталгаажиж Даатгуулагч Монгол улсын хилээс гарснаар үйлчилж эхэлнэ.
- 1.3 Гэрээг Монгол болон гадаад хэл дээр үйлдсэн нөхцөлд Монгол хэл дээрх гэрээг давуу эрхтэй хэрэглэнэ.

ХОЁР. ГЭРЭЭНД ХЭРЭГЛЭГДЭХ НЭР ТОМЬЁНЫ ТАЙЛБАР

- 2.1 Талууд гэрээнд заасан нэр томьёог дараах утгаар ойлгоно.
 - 2.1.1 **Даатгалын эрсдэл** – Энэхүү гэрээнд заасан даатгалын зүйлд учирч болох эрсдэлүүдийг;
 - 2.1.2 **Даатгалын нөхөн төлбөр** - Даатгалын тохиолдол үүссэн нөхцөлд Даатгагчаас Даатгуулагчид энэхүү гэрээний дагуу олгох мөнгөн хөрөнгийг;
 - 2.1.3 **Архаг өвчин** - Даатгалын гэрээ байгуулахаас өмнө тухайн өвчнөөр өвчилж, эмчилгээ хийлгэж байсан, өвчний шинж тэмдэг илэрсэн, онош тогтоолгосон, эмчийн заавраар тухайн өвчнөөс урьдчилан сэргийлэх болон эмчилгээний дараах эм тариа хэрэглэж байсан тохиолдол;
 - 2.1.4 **Гэнэтийн осол** - Гэрээний хугацаанд Даатгуулагчийн хүсэл эрмэлзлээс гадуур өвчин эмгэгийн бус шалтгаанаар богино хугацаанд бий болсон, урьдчилан тооцоолох боломжгүй, гаднын хүчин зүйлийн тааламжгүй нөлөөг ойлгоно. Өвчин эмгэгийн улмаас бие болон сэтгэцэд гарсан өөрчлөлтүүд энэ ойлголтод хамаарагдахгүй;
 - 2.1.5 **Эмнэлэг** – Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх чиг үүрэг бүхий магадлан итгэмжлэгдсэн эмнэлэг;

ГУРАВ. ДААТГАЛЫН ХУГАЦАА

- 3.1 Даатгагч гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлсэн;
- 3.2 Даатгалын гэрээг хугацаанаас нь өмнө дуусгавар болгохоор Талууд харилцан тохиролцсон;

ДӨРӨВ. ДААТГАЛЫН ЗҮЙЛ

- 4.1 Даатгуулагчийн амь нас, эрүүл мэнд, хариуцлага, эд хөрөнгө байна.

ТАВ. ДААТГАЛ ҮЙЛЧЛЭХ ГАЗАР НУТАГ

- 5.1 Даатгуулагчийн сонгон даатгуулсан бүс нутагт энэхүү гэрээний хамгаалалт үйлчилнэ.

ЗУРГАА. ДААТГАЛЫН ЭРСДЭЛ

- 6.1 Даатгуулахаар сонгосон багцаас хамааран энэхүү гэрээний 6.2-д зааснаас бусад ДААТГАЛЫН ХАМГААЛАЛТ -Д заасан эрсдэлүүд байна.
- 6.2 **ДААТГАГЧ ДАРААХ ТОХИОЛДОЛД ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭЖ НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОХГҮЙ:**
 - 6.2.1 Даатгалын тухай хуулийн 8.5-д заасан нөхцөлүүд, Даатгуулагчийн буруутай үйл ажиллагаа, гэмт хэргийн чанартай үйлдэлд оролцсон эсвэл залилангийн болон болгоомжгүй, хайхрамжгүй үйлдлийн шууд ба шууд бус хохирол. Мөн сэтгэл гутрал, сэтгэцийн эмчилгээ хийлгэх үеийн үйлдэл, түүний үр дагавар, Амиа хорлох, амиа хорлох үйлдлийн улмаас учирсан гэмтэл, Архи, эм, хортой эм болон хар тамхи, эмчийн жоргүй хэрэглэхийг хориглосон эм тариаг дур мэдэн хэрэглэсэн, сэтгэцийн эмгэгийн болон сэтгэцэд нөлөөлөх эм хэрэглэснээс үүдэлтэй өвчин, эмгэг байдал;
 - 6.2.2 Архаг өвчин, даатгалын хугацаа эхлэхээс өмнө илэрсэн, мэдэгдсэн, оношлогдсон, эмчилгээ хийлгэж байсан өвчин, эмгэгүүд, бэртэл, гэмтэлтэй холбоотой хохирол, нөхөн сэргээх эмчилгээ, жирэмслэлт, төрөлт, үр хөндөлт, тэдгээрийн үр дагавар;
 - 6.2.3 Шил шаазан эдлэл хагарах, баглаа боодлын хангалтгүй байдал, ачааны таних тэмдэг, тэмдэглэл муутай байснаас учрах хохирол;
 - 6.2.4 Даатгал хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнө учирсан, терроризм, бослого, үймээн самуун болон нийтийн хэт бөөгнөрсөн үйл ажиллагаа, цугларалтаас үүдсэн хохирол, радио идэвхт болон цөмийн эрчим хүчний нөлөөлөл, Форс мажорын улмаас учирсан хохиролд Даатгагч гэрээний дагуу хариуцлага хүлээж нөхөн төлбөр олгохгүй.
 - 6.2.5 Протез, ортопед, ортезийн материал болон остеосинтез материал, нүдний шил;
 - 6.2.6 Эмчилгээ хийлгэх, эмнэлэгт үзүүлэх зорилготойгоор зорчсон бол тухай өвчний эмчилгээ, эдгэшгүй өвчний онош тавигдсаны дараа зорчсон;
 - 6.2.7 5 болон түүнээс доош настай хүүхдэд дараах нөхцөл үйлчилнэ. Үүнд: Гахайн хавдар, салхин цэцэг, улаан бурхан, улаан бурхны тууралт, нуруу нугасны төрөлтийн гажиг, хөхүүл ханиад, хоолойн сахуу, полиомиелитээр өвдсөн хүн, менингит болон эдгээртэй холбоотой эмчилгээний зардлыг нөхөн төлөхгүй.
 - 6.2.8 Ковидын халдвар илрүүлэх шинжилгээний төлбөр, ковидоос

үүдэн гарах тусгаарлалтын зардал /үүнд тусгаарлалтын орон байр, зочид буудлын зардал буюу тусгаарлах байрны төлбөр, хоол, хүнс/, ковидоос үүдсэн буцах онгоцны билет солиулах, шинээр билет авах зардал зэрэг нэмэлт зардлыг төлөхгүй.

ДОЛОО. ДААТГАЛЫН ҮНЭЛГЭЭ, ХУРААМЖ

- 7.1 Даатгалын үнэлгээ хураамж нь энэхүү гэрээний ерөнхий мэдээлэлд тусгаснаар байна.

НАЙМ. ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨР ШИЙДВЭРЛЭХ НӨХЦӨЛ

- 8.1 Даатгуулагч гадаад улс оронд даатгалын эрсдэлийн улмаас учирсан хохирлыг дараах хүснэгтийн дагуу нөхөн олгоно. Даатгалын баталгаанд заасан нутаг оронд болон бичигдсэн хугацаагаар хүчинтэй үйлчилнэ.
- 8.2 **Даатгалд хамрах үйлчилгээ, хамгаалалтын дээд хязгаар**

ЭРСДЭЛ	ХАМГААЛ АЛТ
8.2.1 ЭМНЭЛЭГ, ЭМЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ ➢ Даатгуулагч зорчих хугацаандаа гэнэтийн ослын улмаас хэвтэн эмчлүүлэх, хагалгаа, эмчилгээний төлбөр болон эмнэлэг, эмчлэгч эмчийн бичсэн эм тарианы зардлыг эсхүл гэнэтийн ослын улмаас нас барсан тохиолдолд хамгаалалтын хэмжээ хүртэл нөхөн төлнө. ➢ Даатгуулагч нэг удаагийн тохиолдолд Шенгений бүс нутгаас бусад улс руу зорчих хугацаандаа гэнэтийн өвчний улмаас хэвтэн эмчлүүлэх, хагалгаа, эмчилгээний төлбөр болон эмнэлэг, эмчлэгч эмчийн бичсэн эм тарианы зардлыг эсхүл гэнэтийн өвчний улмаас нас барсан тохиолдолд 10,000 ам.доллар хүртэл нөхөн төлнө. ➢ Даатгуулагч Шенгений бүс нутагт зорчих хугацаандаа гэнэтийн өвчний улмаас хэвтэн эмчлүүлэх, хагалгаа, эмчилгээний төлбөр болон эмнэлэг, эмчлэгч эмчийн бичсэн эм тарианы зардлыг эсхүл гэнэтийн өвчний улмаас нас барсан тохиолдолд 30,000 Евро хүртэл нөхөн төлнө. ➢ Түргэний тусламжийн машин дуудах үйлчилгээ USD 50 хүртэл байна. Бүрдүүлэх бичиг баримт:	Тохиролцсон даатгалын үнэлгээ хүртэл
8.2.2 Даатгалын баталгаа, Эмчийн дүгнэлт, Төлбөрийн баримтууд, Бусад	
8.2.3 ЯАРАЛТАЙ ЗӨӨН ТЭЭВЭРЛЭХ ҮЙЛЧЛЭГЭЭ Даатгуулагч гадаад улс оронд гэнэт өвдөх эсвэл гэнэтийн осолд орсон тохиолдолд хамгийн ойрын эмнэлэгт хүргэх эсвэл нутаг орон руу нь тээвэрлэх ажлыг зохион байгуулж, гарсан зардлыг төлнө. Бага хэмжээний эсвэл хүнд биш өвчин, гэмтлийн үед Даатгагч нутаг орон руу нь тээвэрлэх шийдвэр гаргахгүй бөгөөд түргэнээр эсвэл өөр тээврийн хэрэгслээр эмчилгээний тусламж авах тохиромжтой газар руу тээвэрлэнэ. Даатгагч нь Даатгуулагчийн эмчлүүлж буй эмнэлэг, эмчилгээний төвтэй байнгын харилцаатай ажиллан, эмчлэгч эмч нартай зөвлөлдсөний үндсэн дээр хамгийн тохиромжтой тээврийн хэрэгслээр шилжүүлэн тээвэрлэх эсвэл нутаг орон руу нь зөөн тээвэрлэх асуудлыг шийднэ. Бүрдүүлэх бичиг баримт: ✓ Даатгалын баталгаа, Онгоцны тийз эх хувь, Шинэ онгоцны тийз, Тээврийн хэрэгслийн төлбөрийн баримт, Бусад	USD 2,000 хүртэл
8.2.4 ШҮДНИЙ ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ Гадаад улс оронд Даатгуулагч гэнэтийн өвчлөл, гэнэтийн ослын улмаас шүдний эмчилгээний тусламж шаардлагатай болох тохиолдолд шүд авах, шүдний өвдөлт, халдварын эмчилгээг нөхөн төлнө. Бүрдүүлэх бичиг баримт: ✓ Даатгалын баталгаа, Эмчийн дүгнэлт, Төлбөрийн баримт, Бусад	USD 250 хүртэл
8.2.5 ЗӨӨН ТЭЭВЭРЛЭХ (шарил)	USD 5,000 хүртэл

Даатгуулагч гадаад оронд аялах хугацаандаа нас барсан тохиолдолд шарилыг тээвэрлэн, нутагт нь авч ирж улмаар оршуулах газар хүргэх тээврийн зардлыг хариуцна. Оршуулах, чандарлах эсвэл оршуулгын ёслолын үйл ажиллагааны зардал хамаарахгүй. Бүрдүүлэх бичиг баримт: ✓ Даатгалын баталгаа, Морг хүлээн авсан бичиг, Агаарын тээврийн компанийн бичиг, Төлбөрийн баримт, Бусад		Энэ тохиолдолд агаарын тээврийн компанийн албан ёсны тодорхойлолтыг үндэслэнэ. Бүрдүүлэх бичиг баримт: ✓ Даатгалын баталгаа, Агаарын тээврийн компанийн тодорхойлолт, Тооцооны хуудас (шаардлагатай зүйлс худалдаж авсан), Бусад	
8.2.6 МОНГОЛ РУУ ЯАРАЛТАЙ БУЦАХ Даатгуулагчийг гадаад улс оронд аялах хугацаанд гэр бүлийн гишүүдээс хэн нэгэн нь (зөвхөн хамт амьдардаг) нас барсны улмаас Даатгуулагч аяллыг зогсоон маршрутын бус тээврийн хэрэгслээр эх орондоо яаралтай буцах тохиолдолд зардлыг төлнө. Энэ тохиолдолд аялал зогсоох шаардлагатайг нотлох бичиг баримт эсвэл гэрчилгээ (нас барсны)-г бүрдүүлнэ. Үүнд: Даатгуулагчаас өөр этгээд, хүүхдийн зардал хамаарахгүй. Бүрдүүлэх бичиг баримт: ✓ Даатгалын баталгаа, Гэр бүлийн гишүүний нас барсны гэрчилгээ, Даатгуулагч болон нас барсан хүнийг гэр бүл гэдгийг нотлох баримт, Онгоцны тийз, Бусад	USD 1,000 хүртэл	8.2.11 НИСЛЭГ СААТАХ Даатгуулагчийн хуваарьт нислэг 6 цагаас дээш хугацаагаар хойшлогдсон тохиолдолд нислэг саатсаны улмаас гарах нэмэлт зардалд (зочид буудал, хоол, унааны зардал) зориулан дараах хязгаарт багтаан эх баримтуудыг үндэслэн нөхөн төлбөр олгоно. - 6 цагаас дээш цагаар хойшлогдсон тохиолдолд 45 ам.доллар - 12 -оос дээш цагаар хойшлогдсон тохиолдолд нэмэлт 45 USD - 18-аас дээш цагаар хойшлогдсон тохиолдолд нэмэлт 45 USD - 24-өөс дээш цагаар хойшлогдсон тохиолдолд нэмэлт 45 USD Төлбөрийн нэхэмжлэлийн эх хувийг үндэслэн 180 ам.доллар хүртэл нөхөн төлнө. Энэхүү хамгаалалт нь агаарын тээврийн компани болон нисэх эсвэл буух онгоцны буудал эсвэл үйлчилгээ үзүүлэгч гэрээт компаниудын ажилчдын ажил хаялтын улмаас нислэг хойшилсон тохиолдолд хамаарахгүй. Мөн тогтмол бус эсвэл чартер нислэг саатсан тохиолдолд хамаарахгүй. Монголоос нисэх үед нислэг хойшилсон тохиолдолд хамаарахгүй. Даатгуулагч нь тээвэрлэгч компани, түүний төлөөлөгч агентаас нислэг хойшлогдсон өдөр, шалтгаан зэргийг тодорхой заасан, нислэг хойшлогдсон тухай тодорхойлолтыг ирүүлнэ. Энэ хамгаалалтын дагуу нөхөн төлбөрийг олгохдоо баталгаажуулалт хийлгэсэн суудал бүхий онгоцны тийзэд заасан хугацаанаас эхлэн тооцно. Бүрдүүлэх бичиг баримт: ✓ Даатгалын баталгаа, Нислэгийн тийз эх хувиараа, Агаарын тээврийн компанийн нислэг хойшлогдсон тухай тодорхойлолт, Тооцооны хуудас (хойшлогдсон хугацаанд шаардлагатай зүйлс худалдаж авсан), Бусад	USD 180 хүртэл
8.2.7 ХУУЛИЙН ЗАРДАЛ Даатгуулагч гадаад оронд байх хугацаандаа Даатгуулагчийн өөрийн буруутай зам тээврийн ослын улмаас шүүхэд татагдах тохиолдолд хуульч, өмгөөлөгчийн зардлыг 1,100 ам.доллар хүртэл нөхөн төлнө. Бүрдүүлэх бичиг баримт: ✓ Даатгалын баталгаа, Замын цагдаагийн тодорхойлолт, Хуулийн байгууллагын болон бусад холбогдох байгууллагын тооцооны хуудас, Бусад	USD 1,100 хүртэл	8.2.12 НИСЛЭГЭЭС ХОЦРОХ Даатгуулагч гадаад руу нисэх эсвэл эх орон руугаа буцаж нисэхдээ нийтийн тээврийн үйлчилгээний эвдрэл гэмтэл эсвэл тухайн зорчиж явсан тээврийн хэрэгслийн осол, эвдрэлийн улмаас олон улсын нисэх газартаа очиж чадаагүйн улмаас урьдчилан захиалсан байсан нислэгээс хоцорсон тохиолдолд Даатгагч нь зайлшгүй шаардлагатай нэмэлт зардал, зочид буудлын зардлын баримтыг үндэслэн даатгалын хамгаалалтын хүснэгтэд заасан хэмжээ хүртэл Даатгуулагчид нөхөн төлнө. Хамаарахгүй нөхцөл: - Даатгуулагчийн хариуцах хэсэг; - Ослын хэмжээ, нөхцөл байдлын талаар нотолсон цагдаагийн тодорхойлолт байхгүй тохиолдол; - Даатгуулагч нь нислэгийн компанийн зөвлөмжийн дагуу нисэх газартаа ирэхийн тулд шаардлагатай алхмуудыг хийгээгүйн улмаас учирсан хохирол; - Тээврийн хэрэгсэл нь шаардлагатай засвар, үйлчилгээг хийлгээгүй байсны улмаас учирсан хохирол;	500 USD хүртэл
8.2.8 ГАДААД ПАСПОРТ, ЖОЛООНЫ ҮНЭМЛЭХ, ИРГЭНИЙ ҮНЭМЛЭХ АЛДАГДАХ Гадаад паспорт, жолооны үнэмлэх, иргэний үнэмлэхээ хаяж гээгдүүлсэн тохиолдолд шинээр авах эсвэл түүнтэй адилтгах бичиг баримтыг консулын газраас авах зардлыг нөхөн төлнө. Бүрдүүлэх бичиг баримт: ✓ Даатгалын баталгаа, Шинэ паспорт эсвэл холбогдох бусад баримт бичгийн хуулбар, Шинэ бичиг баримт авахтай холбогдсон төлбөрийн баримт, Цагдаагийн тодорхойлолт, Бусад	USD 200 хүртэл	8.2.13 КОВИД *Даатгуулагч нь гадаад улс оронд байх хугацаандаа ковид 19 халдвараар өвчилсөн нь тогтоогдсон тохиолдолд эмчилгээний зардлыг Эмчийн дүгнэлтийн дагуу хийгдсэн аливаа эмчилгээ, шинжилгээ, эм тариа, ор хоногийн зардал зэргийг эмнэлэг эмчилгээний зардал хэлбэрээр хүснэгтэд заасан үнэлгээ хүртэл нөхөн төлнө. Үүнд: a) Амбулаторийн эмчилгээний зардал b) Хэвтэн эмчлүүлэх ор хоног, эмчилгээний зардал c) Эм, тариа, эмчилгээний зардал.	Эмчилгээний зардал Шенгенийн бүс нутгуудад (Schengen) USD 50,000 хүртэл Бусад оронд USD 500 хүртэл
8.2.9 НИСЛЭГТ БҮРТГЭЛТЭЙ АЧАА ТЭЭШ АЛДАГДАХ ҮЕИЙН НӨХӨН ТӨЛБӨР Даатгуулагчийн бүртгүүлсэн ачаа тээш болон эд зүйлс тээвэрлэгчийн үйл ажиллагааны улмаас алдагдсан тохиолдолд олж авах, нөхөн бүрдүүлэхэд зориулан 210 ам.доллар хүртэл нөхөн төлнө. Даатгуулагч ачаа тээшин доторх эд зүйлийн жагсаалт, үнэ, худалдан авсан хугацаа зэрэг тодорхой мэдээллийг өгөх шаардлагатай. Олон улсын ачаа тээшинд хүлээх хариуцлагын журмыг үндэслэн нөхөн төлбөрийг тооцоолно. Алдагдсан ачаа тээш доод тал нь 21 хоног буюу тээвэрлэгч байгууллагын санал болгосон хугацаанд олдох боломжгүй нь тогтоогдсон нөхцөлд нөхөн төлбөрийг олгоно. Энэхүү хамгаалалтад бэлэн мөнгө, үнэт эдлэл, дебет болон кредит карт аливаа нэгэн бичиг баримт хамаарахгүй. Бүрдүүлэх бичиг баримт: ✓ Даатгалын баталгаа, Агаарын тээврийн компанийн тодорхойлолт (Хэрэв агаарын тээврийн компаниас авч чадаагүй бол түүний төлөөлөгчийн газраас тодорхойлолт авч болно), Тооцооны хуудас, Тээвэрлэгч компанийн нөхөн төлбөр, Бусад	USD 210	ЕС. ХОХИРЛЫГ МЭДЭГДЭХ 9.1 Аливаа даатгалын тохиолдлоор Даатгуулагч шинжилгээ, оношилгоо, эмчилгээ хийлгэх тохиолдолд цахимаар Мөнх Даатгал ХХК-д мэдэгдэнэ.	
8.2.10 АЧАА ТЭЭШ ХОЦРОХ ҮЕИЙН НӨХӨН ТӨЛБӨР Даатгуулагчийн ИАТА-ийн бүрэлдэхүүнд багтдаг агаарын тээврийн компанид бүртгүүлсэн ачаа тээш 6 цагаас дээш хугацаагаар хойшлогдсон тохиолдолд ойр зуурын хэрэгцээтэй зүйлс худалдан авах зориулан 100 ам.доллар хүртэл нөхөн төлбөр олгоно.	USD 100		

24 Цагийн нэгдсэн шуурхай албаны утас: (+976)-7599-1100
Мэйл: info@munkhdaatgal.mn

АРАВ. НӨХӨН ТӨЛБӨР ОЛГОЛТ

- 10.1 Хохирол учирсан даруйд Даатгуулагч өөрт мэдэгдэж байгаа дэлгэрэнгүй мэдээллийг Даатгагчид мэдэгдэн, учирсан хохирлыг баталгаажуулах арга хэмжээг авах ба Даатгагчтай тохиролцсон хугацаанд хохирлын талаарх баримт материалыг бүрдүүлж ирүүлнэ.
- 10.2 Нөхөн төлбөрийн материал бүрдүүлэлт
- 10.2.1 Даатгалын гэрээ, баталгааны хуулбар
- 10.2.2 Гадаад паспортын зурагтай хэсгийн хуулбар
- 10.2.3 Е-Тасалбар
- 10.2.4 Эмчийн дүгнэлт, эмчилгээний нэхэмжлэх, төлбөрийн баримт /эмчилгээ хийсэн тохиолдолд/
- 10.2.5 Цагдаагийн тодорхойлолт (хулгай, дээрэм, гадаад паспорт, түрийвчээ алдах)
- 10.2.6 Агаарын тээврийн компанийн албан бичиг (нислэг, ачаа тээш хойшлох, хоцрох эсвэл нислэг цуцлагдах тохиолдолд)
- 10.2.7 Хуульчийн албан бичиг (хууль эрх зүйн хамгаалалтын хувьд)
- 10.2.8 Шаардлагатай тохиолдолд бусад баримтууд
- 10.3 Даатгагч шаардлага хангасан нөхөн төлбөрийн нэхэмжлэл болон бусад материалыг бүрэн хүлээн авснаас хойш ажлын 1-30 хоногийн дотор нөхөн төлбөрийг шийдвэрлэнэ, хуулийн хугацаанд нөхөн төлбөр олгоогүй тохиолдолд Иргэний хуулийн 232.6 дахь хэсэгт заасны дагуу хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 0.5 хувиар алданги тооцож Даатгуулагчийн нөхөн төлбөр дээр нэмж олгоно.
- 10.4 Нэмэлт материал шаардлагатай тохиолдолд хугацааг сунгаж болно.
- 10.5 Эмчилгээний зардлыг өөр даатгалын компаниас эсвэл улсын нийгмийн даатгалаас төлсөн нөхцөлд Даатгагч хохирлыг үлдэх хэмжээгээр төлнө

АРВАН НЭГ. ДААТГУУЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 11.1 Гэрээний нөхцөлийн дагуу даатгалаар хангагдах, нөхөн төлбөр олгохыг Даатгагчаас шаардах.
- 11.2 Даатгагч гэрээний үүргээ биелүүлээгүй эсхүл Даатгагчийн эрх, үүрэг шинэ эзэмшигчид шилжвэл гэрээг цуцлах, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг тавих эрхтэй.
- 11.3 Буруутай этгээдээс хохирлыг нэхэмжлэн авах Даатгагчийн эрхийг Даатгуулагчийн зүгээс ямар нэгэн хэлбэрээр хязгаарласан эсвэл багасгасан тохиолдолд Даатгагч Даатгагдагчид олгосон нөхөн төлбөрийг тэр хэмжээгээр буцаан нэхэмжилнэ.
- 11.4 Даатгуулагч даатгалын талаар үнэн зөв, бодитой мэдээлэл өгөх үүрэгтэй ба хуурамч баримт бүрдүүлсэн, энэ гэрээгээр олгогдох нөхөн төлбөрийг хууран мэхлэх замаар авах гэж оролдсон нь нотлогдвол гэрээ цуцлагдаж, нөхөн төлбөр авах боломж бүрэн алдагдах ба даатгалын хураамж буцаан олгогдохгүй болно.
- 11.5 Даатгуулагч даатгалын тохиолдол бий болсон тухай Даатгагчид нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

АРВАН ХОЁР. ДААТГАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

- 12.1 Даатгагч Даатгуулагчийг гэрээнд заасны дагуу даатгалаар хангах үүрэгтэй
- 12.2 Даатгалын хууль, гэрээний нөхцөлийг Даатгуулагчид танилцуулах үүрэгтэй
- 12.3 Даатгалын тохиолдол бий болж, Даатгагчийн төлбөл зохих нөхөн төлбөрийн хэмжээг тогтоосны дараа Даатгагч үүргээ гүйцэтгэх үүрэгтэй.
- 12.4 Даатгуулагч гэрээний үүргээ биелүүлээгүй эсхүл Даатгуулагчийн эрх, үүрэг шинэ эзэмшигчид шилжвэл гэрээг цуцлах, нэмэлт, өөрчлөлт оруулахыг шаардах эрхтэй
- 12.5 Даатгуулагч нь гэрээнд заасан хугацаанд багтаж Даатгагчид мэдэгдээгүй, нөхөн төлбөрийн материалаа бүрэн бүрдүүлж өгөөгүй тохиолдолд нөхөн төлбөр олгохоос татгалзах эрхтэй.

АРВАН ГУРАВ. БУРУУТАЙ ТАЛААС ТӨЛБӨР НЭХЭМЖЛЭХ

- 13.1 Даатгалын тухай хуулийн 8.7-д заасныг үндэслэн Даатгагч аливаа хохирлыг нөхөн барагдуулах хугацаанд буруутай этгээдээс төлбөрөө нэхэмжлэх эрхтэй ба Даатгуулагч Даатгагчид бүхий л талын туслалцаа үзүүлж хамтран ажиллах үүрэгтэй.
- 13.2 Буруутай этгээдээс хохирлыг нэхэмжлэн авах Даатгагчийн эрхийг Даатгуулагчийн зүгээс ямар нэгэн хэлбэрээр хязгаарласан эсхүл багасгасан тохиолдолд Даатгагч Даатгуулагчид олгох нөхөн төлбөрийн дүнг олгохоос татгалзах эсхүл багасгасан хэмжээгээр нь хасах замаар энэ алдагдлаа нөхөж авах эрхтэй.
- 13.3 Даатгуулагч болон түүний ажилтан даатгалын тохиолдолд буруутай байх тохиолдолд Даатгагч нь хохирлын нөхөн төлбөрийг буруутай этгээдээс нэхэмжлэх эрхээс татгалзана. Харин даатгалын хохиролд буруутай этгээд нь гуравдагч этгээд бол хохирлыг нэхэмжлэх эрхтэй.

АРВАН ДӨРӨВ. ГЭРЭЭ ЦУЦЛАХ, ХУРААМЖ ТОХИРГОО, ХАРИУЦЛАГА ТООЦОХ

- 14.1 Даатгагч болон Даатгуулагч нь гэрээнд өөрөөр заагаагүй бол энэхүү гэрээг хугацаанаас өмнө дангаараа цуцлах эрхгүй.
- 14.2 Даатгуулагч энэ гэрээгээр олгогдох нөхөн төлбөрийг хууран мэхлэх замаар авах гэж оролдсон нь илэрвэл гэрээ цуцлагдаж, нөхөн төлбөр авах боломж бүрэн алдагдах ба даатгалын хураамж буцааж олгогдохгүй болно.
- 14.3 Дараах үндэслэлээр даатгалын гэрээг цуцална.
- 14.3.1 ЭСЯ -аас гадаад улсад зорчих виз олгогдоогүй
- 14.3.2 ЭСЯ -аас гадаад улсад зорчих виз олгогдсон боловч хүндэтгэх шалтгааны улмаас тухайн оронд зорчих боломжгүй болсон (энэ тохиолдолд үйл ажиллагааны зардал 20 хувь суутгагдан буцаан олголт хийгдэнэ)

АРВАН ТАВ. БУСАД

- 15.1 Энэхүү даатгалын гэрээг 2 (хоёр) хувь үйлдэж, Даатгагч 1 хувь, Даатгуулагч 1 хувийг хадгалах ба хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй.
- 15.2 Гэрээтэй холбогдон гарсан маргаантай асуудлыг гэрээний Талууд хэлэлцээрийн аргаар зохицуулахыг эрхэмлэх бөгөөд эс чадвал СЗХ-д хандаж шийдвэрлүүлнэ.
